**Ази, Номхон далайн мэдээллийн эдийн засаг,**
**нийгэм, улс төр - Цахим хялбаршуулал цувралууд**

## Танилцуулга

НҮБ-ын Ази, Номхон далайн мэдээллийн хөгжлийн хөтөлбөрөөс (APDIP), Зүүн Өмнөд Азийн орнуудын Цахим холбоотой (e-ASEAN) хамтран Мэдээлэл, Холбооны Технологийн (МХТ) мэргэжлийн бус бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын Мэдээлэл, Харилцааны Технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хялбаршуулсан хэлбэртэй “Мэдээллийн эдийн засаг, нийгэм, улс төр” хэмээх Цахим хялбаршуулал цувралыг бэлтгэн гаргаж байгаа билээ.
Энэхүү цувралаас МИДАС/МОНИТА Төрийн бус байгууллага Олон Улсын Хөгжлийн Судалгааны Агентлагийн (IDRC) санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Мэдээлэл, Холбооны Технологийн бодлогын судалгаа” төслийн хүрээнд APDIP-ийн зөвшөөрлөөр орчуулан “Миний компьютер” сэтгүүлийн “Бодлого боловсруулагчдад” шинэ буланд цувралаар нийтэлсэн болно.

## Өмнөх үг

Өнөөдөр Ази, Номхон далайн орнуудад тулгараад байгаа олон асуудлуудын нэг нь тэдгээрийн засгийн газар болон иргэний нийгмийг даяарчлах, мэдээлэл холбооны технологийн хувьсгалд бэлтгэх явдал юм. Бодлого боловсруулагчид, бизнесийн удирдлагууд, Төрийн бус байгууллагын (ТББ) ажилтнууд, эрдэмтэн судлаачид болон жирийн иргэд бодит биелэлээ олж байгаа мэдээллийн эдийн засгийн үед өөрсдийн нийгмийн байр суурийг илүү өрсөлдөх чадвартай болгохыг эрмэлзэж байгаа билээ.

Зүүн Өмнөд Азийн орнуудын Цахим холбоо (e-ASEAN) ба НҮБ-ын Ази, Номхон далайн мэдээллийн хөгжлийн хөтөлбөр нь улс орнууд Мэдээлэл, Холбооны Технологийг (МХТ) ашигласнаар мэдээллийн эрин үед тулгарч болох хүндрэл, бэрхшээлүүдийг даван туулж болно гэдэгтэй санал нэгтэй байна. МХТ-ийн тусламжтайгаар тэд нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийн өндөр түвшин рүү үсрэх боломжтой. Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, төлөвлөгчид, судлаачид, хэрэгжүүлэгчид, санал бодлоо илэрхийлэгчид болон бусад оролцогсдод энэхүү үсрэлтийг хийхэд Цахим хялбаршуулал зохих хувь нэмрээ үзүүлнэ гэж бид итгэж байна.

Цахим хялбаршуулал цуврал нь уншигчдад мэдээллийн эрин үетэй холбоотой төрөл бүрийн тодорхойлолт, нэр томъёо, хандлага, ойлголтууд болон бусад асуудлуудыг ойлгуулах зорилготой. Хялбаршуулалыг энгийн ойлгоход хялбар хэлээр бичсэн. Мөн түүнчлэн бодлого боловсруулагчид ба шийдвэр гаргагчдад мэдээллийн эдийн засагт тохирох бодлого, стратеги боловсруулах, тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхэд туслах зорилгоор жишээ, тохиолдлууд, сургамжууд болон шилдэг туршлагуудыг оруулаад байна.

Цуврал нь дараах хялбаршуулалуудаас бүрдэнэ. Үүнд:

1. Мэдээллийн эрин үе
2. Сүлжээ, вэбүүд ба мэдээллийн дэд бүтэц
3. Цахим арилжаа ба цахим бизнес
4. Мэдээллийн эдийн засгийн хууль эрх зүй, зохицуулалтын асуудлууд
5. Цахим засаглал
6. Мэдээлэл, Холбооны Технологи боловсролд
7. Гени, Технологи ба бодлого Биотехнологи

8. Эх код нь нээлттэй, үнэгүй программ хангамж
9. Ядуурлыг бууруулахад Мэдээлэл, Холбооны Технологи

Эдгээр цуврал хялбаршуулалуудтай [www.eprimers.org](http://www.eprimers.org) эсвэл [www.apdip.net](http://www.apdip.net) вэбүүдээс англи хэлээр бүрэнэхээр нь танилцаж болно.
Танд энэ цувралыг Ази, Номхон далайн бүс дэх бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хөгжлийн мэргэжилтнүүдэд зориулан хэвлэв. Зөвлөгөө, сурталчилгаагаар МХТ-ийн орчинг бүрдүүлэх зорилгобүхий НҮБ-ын APDIP болон 10 улс гишүүдыг эгнээндээ нэгтгэсэн Зүүн өмнөд азийн холбооны МХТ-ийг хөгжилд ашиглах санаачлагын байгууллага e-ASEAN хүргэж байна. Цувралд оруулахад хэрэгцээтэй шинэ сэдэв, асуудлаар таны санал бодлыг бид дуртай хүлээн авна.
Эцэст нь бид энэхүү цувралыг боловсруулахад оролцсон зохиогч ид, судлаач ид, хянагч ид болон бусад багийн хамт олонд талархал илэрхийлье.

Роберто Р. Романо e-ASEAN байгууллагын тэргүүн (2000-2002), Филиппин улс, Манила хот

Шахид Ахтар
НҮБ-ийн APDIP-ийн хөтөлбөрийн зохицуулагч Малайз улс, Куала Лумпур хот
[www.apdip.net](http://www.apdip.net)

Эхний хэсгийг толилуулж байна.
Доктор Эммануэл С. Лаллана, Маргарет Н Уй

**Мэдээллийн эрин үе. Оршил**

Ирээдүйг төсөөлнө гэдэг нь ямагт аз туршсан асуудал байдаг. Ихэнх тохиолдолд төсөөлж байсан ирээдүй нь цаг хугацаа болоход өөр болон хувирна. Өнөөгийн байдлыг харуулах зорилгоор 20 эсвэл 10 жилийн өмнө бүтээгдсэн киноонуудыг бодоод үз. Тэдгээр нь ирээдүйг зөв төсөөлсөн гэхэд тун хэцүү.
Ирээдүйн тухай төсөөлөл нь яагаад амжилтгүй болдгийн шалтгаан маш энгийн – түүхийг бүтээхэд нөлөөлдөг олон хүчин зүйлсийг судлаач ид, шинжээч ид, эрдэмтэд болон урлагийнхан тэр бүр бүрэн тайлж чаддаггүйд л оршино.
Бид ирээдүйг төсөөлөх гэж оролдсоор л байна. Яагаад гэвэл юу болоод өнгөрсөн бэ гэдгийг сонирхохоос илүү юу болох гэж байна вэ гэдэг нь бидний сонирхлыг татдаг. Яагаад гэвэл бид ирээдүйд хөрөнгө оруулалт хийсэн ба бид тэр үед амьдарна.
Ирээдүйг төсөөлнө гэдэг нь түүний талаар тодорхой нэг ойлголтыг бий болгох байдаг. Бид амьдрахыг хүсч буй тэр ирээдүйгээ төсөөлдөг. Хандлагууд, урьдчилсан тооцоонуудыг үндэслэн бид сонголт хийдэг. Хэдийгээр бүх нөлөөлөх хүчин зүйлсийг тооцож үзсэн ч гэсэн бид заримд нь бусдаас илүү ач холбогдол өгдөг. Хэдийгээр бүх үр дүнг урьдчилан харж болохоор байвч бид заримыг нь илүүд үздэг. Энэ нь оюун ухааны шударга бус байдал огт биш Энэ нь бүх юм иймл байдгаас болж байгаа зүйл. (Тийм биш байсан бол шударга биш явдал болно)
"Мэдээллийн эрин үе" хялбаршуулал нь "Мэдээллийн эдийн засаг, нийгэм, улс төр" цувралын бусад хялбаршуулалуудын адил ирээдүйг төсөөлөхдөө түүнийг Мэдээлэл, Холбооны Технологитой (МХТ) уялдуулан авч үзсэн болно.
Энэхүү хялбаршуулалд тоон технологи болон МХТ-ийн хувьсгалын талаархи тоймоос эхэлж тэдгээр нь эдийн засаг, бизнес болон ажил эрхлэлтэнд хэрхэн нөлөөлж байгааг тусгалаа. Энд мөн МХТ-ийг эн тэргүүнд тавих болсон нь хувь хүмүүс, гэр бүл, нийгэмд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэсэн Төр засгийн систем болон засаглалд технологийн өөрчлөлтийн нөлөөг мөн адил авч үзсэн. Мөн түүнчлэн МХТ-ийг ашиглах боломжтой ба боломжгүй хүмүүсийн хоорондын ялгаа улам бүр нэмэгдэж байгаа мэдээллийн ялгавартай байдлаас үүсэн гарч буй асуудлуудыг гарган харууллаа.

Эцэст нь бид мэдээллийн эрин үед нөлөөлөх хийн тулд түүнийг төсөөлж байна.